

# ОРХОНДАЛАЙ ХК

## ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр:	“Орхондалай” ХК
Хаяг:	Сэлэнгэ аймгийн Орхон сумын 2 дугаар баг Бэлэндалайд байрлах өөрийн байр Утас: 99996774
Хурал хуралдах өдөр, цаг:	2024 оны 05 дугаар сарын 20-ны өдөр 10.00 цагт
Хурал хуралдах газар /хаяг, байршил/:	Сэлэнгэ аймгийн Орхон сумын 2 дугаар баг Бэлэндалайд байрлах өөрийн байр
Хурлын төрөл:	Ээлжит бус
Хурал зарлагч:	Төлөөлөн удирдах зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо:	2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо:	2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр
Бүртгэлийн өдөр:	2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр
Гэрээний дагуу хурлын баримт бичгийг Үнэт цаасны компанид хүргүүлэх огноо:	2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр
Хүргүүлсэн огноо:	2024 оны .....-р сарын .....-ны өдөр
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэр:	Дарга – Г.Бямбарагчаа Гишүүд - З.Пүрэвдорж Д.Саруултуяа
Баримт бичгийн жагсаалт /хавсралтаар/ :	
Баримт бичгийн хуудасны тоо:	..... ширхэг ..... хуудас

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
КОМИССЫН ДАРГА ..... /Б.НЯМБАЯР/

2024 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр



## ОРХОНДАЛАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН

### УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 04 дүгээр сарын 03

№1

Бэлэндалай

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 76 дугаар зүйлийн 76.1.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Орхондалай” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Орхондалай” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2024 оны 05 дугаар сарын 20-ны даваа гарагийн 10.00 цагт Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалайд байрлах компанийн өөрийн байранд хуралдахаар тогтоосугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.

- “Орхондалай ХК”-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах

- “Орхондалай ХК”-ийн дунд хугацааны хөгжлийн бодлогыг хэлэлцэж батлах

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах хороо болон Монголын Хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга /Г.Нарантуяа/-д даалгасугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдрөөр тогтоосугай.

5. “Орхондалай” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг Монголын Хөрөнгийн биржийн цахим хуудас болон “Өдрийн сонин”-оор дамжуулан 2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр олон нийтэд мэдээлж зарын давталтыг 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин олон нийтэд мэдээлсүгэй.

6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар гарсан шийдвэрийн төсөл, танилцуулга, баримт бичгийг 2024 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр багтаан үнэт цаасны брокер, диллерийн компанид хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал /Б.Нямбаяр/-д даалгасугай.

7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зарыг загварын 1 дүгээр хавсралтаар, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 2

дугаар хавсралтаар, хурлын саналын хуудсыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

8. "Орхондалай" ХК-ийн хувьцаа эзэмшигчийн ээлжит бус "Хурлын дэг"-ийг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

9. Хувьцаа эзэмшигчдийн саналыг урьдчилсан байдлаар 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 18 цаг хүртэл хугацаанд брокер, диллерийн компаниар дамжуулан эсхүл Сэлэнгэ аймгийн Орхон сумын Бэлэндалай 2 дугаар багт байрлах өөрийн байранд бичгээр урьдчилан авах боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулагч Комиссын дарга /Б.Нямбаяр/-д даалгасугай.

10. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Б.Нямбаяр, хурлыг зохион байгуулах комиссын гишүүдээр Б.Эрдэнэчимэг, Д.Мөнхбаяр нарыг томилсугай.

11. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тооллогын комиссын даргаар Б.Бямбарагчаа, гишүүдээр П.Пүрэвдорж, Д.Саруултуяа нарыг томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА ..... Б.БАЯРХҮҮ/



**ОРХОНДАЛАЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН**  
**УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2024 оны 04 дүгээр сарын 03

№2

Бэлэндалай

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 6 дугаар бүлгийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6-р заалтыг үндэслэн компанийн 2023 оны үйлдвэрлэлийн үр дүн, тус оны 09 дүгээр сард цаг агаарын тойм мэдээнд дурдагдаагүй, гэнэт 5 хоног үргэлжлэн орсон их хэмжээний усархаг бороонд ангилан хадсан тариан түрүү газар дээрээ ургаж, үр тарианы цавуулаг буурч, их хэмжээний уураг алдагдаж, хураасан улаан буудай нь хүнсний улаан буудайн стандартад тэнцэхгүй болсон, гурилын үйлдвэрийн дүгнэлт зэргийг харгалзан ТОГТООХ нь:

1. Жилийн аудитлагдсан тайлангийн дүнгээр 56.281.867,31 /тавин зургаан сая хоёр зуун наян нэгэн мянга найман зуун жаран долоо/ төгрөгийн алдагдалтай ажилласан тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтсугай.
2. Компанийн тухай хуулинд заасны дагуу хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх Монголын Хөрөнгийн биржид албан бичиг явуулахыг Гүйцэтгэх захирал /Б.Нямбаяр/-д даалгасугай.

ДАРГА



/Б.БАЯРХҮҮ/